



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангай сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2023/09/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2024 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор: А.Пүрэвцэцэг Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.5.1 Орон нутгийн төсвийн орлого, зардлын төлөвлөлт	11
3.5.2 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Төсвийн шууд захирагчийн аудитын дүнгийн талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол улсын засгийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХГБХХГ	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМГИЙН ХАНГАЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Д.ӨРНӨХБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Хангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангай сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

МУЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу тус орлогыг тайлант оноос захиран зарцуулж, тайлагнах болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 12 үндсэн зорилтын хүрээнд 134 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 91.17 хувийн гүйцэтгэлтэй үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	590,433.30	734,697.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	197,877.00	301,025.40
33	АВЛАГА	300,352.40	345,416.60
35	БАРАА МАТЕРИАЛ	44,192.40	47,430.60
36	НӨӨЦИЙН БАРАА	48,011.50	40,825.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,497,478.50	2,617,436.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,497,478.50	2,617,436.10
39200	Биет хөрөнгө	2,418,206.50	2,538,164.10
39300	Биет бус хөрөнгө	79,272.00	79,272.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,087,911.80	3,352,133.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,087,911.80	3,352,133.60
51	Засгийн газрын хувь оролцоо	3,087,911.80	3,352,133.60
51100	Засгийн газрын оруулсан капитал	356,050.10	356,050.10
51200	Хуримтлагдсан үр дүн	2,665,843.80	2,930,065.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,018.00	66,018.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,087,911.80	3,352,133.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,379,858.80	1,662,974.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	283,444.50	324,952.80
110	Орлогын албан татвар	175,930.40	236,391.30
1100	Хувь хүний орлогын албан татвар	175,917.80	236,347.00
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	12.6	44.2
113	Хөрөнгийн албан татвар	70,130.20	60,773.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	37,383.90	27,788.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	545,843.20	378,115.60
120	Нийтлэг татварын бус орлого	545,843.20	378,115.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,550,571.20	959,906.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,726,674.50	1,036,481.70

Архангай аймгийн Хангай сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,726,674.50	1,024,678.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	826,470.50	1,012,771.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	355,094.80	458,633.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,553.40	57,768.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,710.70	13,642.20
2104	Хангамж, бараа материалын зардал	40,101.90	48,661.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,670.80	10,286.60
2107	Томилолт, зочны зардал	16,136.00	19,560.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,739.50	171,080.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	191,463.50	233,139.00
212	ТАТААС	4,032.40	3,635.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	896,171.50	8,271.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	11,803.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	653,184.40	626,492.70
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,133,832.80	362,270.80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,924,480.20	1,395,103.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	283,444.50	324,952.80
110	Орлогын албан татвар	175,930.40	236,391.30
1100	Хувь хүний орлогын албан татвар	175,917.80	236,347.00
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	12.6	44.2
113	Хөрөнгийн албан татвар	70,130.20	60,773.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	37,383.90	27,788.60
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,707.60	20,480.60
1181	Газрын төлбөр	10,947.40	230.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	12,728.90	7,077.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90,464.60	110,244.60
120	Нийтлэг татварын бус орлого	90,464.60	110,244.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,550,571.20	959,906.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,578,681.50	824,401.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,578,681.50	824,401.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	672,386.20	811,631.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	355,185.00	458,633.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,463.10	57,768.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,340.70	13,642.20

Архангай аймгийн Хангай сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	37,983.30	41,075.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,858.00	11,050.00
2107	Томилолт, зочны зардал	15,900.00	19,560.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,824.00	173,066.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,832.10	36,834.30
212	ТАТААС	4,492.40	3,999.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	901,802.80	8,770.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	345,798.70	570,702.10
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	373,406.20	377,553.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	373,406.20	377,553.70
2200	Дотоод эх үүсвэрээр	373,406.20	377,553.70
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-373,406.20	-377,553.70
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-200,000.00	-90,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	200,000.00	90,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-227,607.50	103,148.40

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,626,210.30	9,626,210.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-57,650.00	-57,650.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,568,560.30	9,568,560.30
9	Тайлант үеийн үр дүн	-6,480,648.50	-6,480,648.50
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,087,911.80	3,087,911.80
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,087,911.80	3,087,911.80
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,087,911.80	3,087,911.80
19	Тайлант үеийн үр дүн	264,221.80	264,221.80
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	3,352,133.60	3,352,133.60

2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,474,502.70	1,287,794.80	-186,707.90	-12.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	898,058.10	823,720.80	-74,337.30	-8.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	885,679.50	811,450.60	-74,228.90	-8.38

Архангай аймгийн Хангай сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,458.30	458,633.30	-33,825.00	-6.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,496.90	57,768.60	-3,728.30	-6.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	172,222.90	167,081.40	-5,141.50	-2.99
2104	Хангамж, бараа материалын зардал	40,259.50	39,167.70	-1,091.80	-2.71
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,543.60	28,498.10	-45.50	-0.16
2107	Томилолт, зочны зардал	19,608.80	19,560.20	-48.60	-0.25
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,484.50	3,906.70	-8,577.80	-68.71
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,605.00	36,834.20	-21,770.80	-37.15
212	ТАТААС	4,000.00	3,999.46	-0.54	-0.01
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,000.00	3,999.46	-0.54	-0.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,378.60	8,270.70	-107.90	-1.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,378.60	8,270.70	-107.90	-1.29
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	468,773.90	374,074.01	-94,699.89	-20.20
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	107,670.70	90,000.00	-17,670.70	-16.41
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,474,502.70	1,315,991.60	-158,511.10	-10.75
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,190,375.40	12,141,236.86	10,950,861.46	919.95
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	284,127.30	101,854.75	-182,272.55	-64.15
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	111,999.00	111,999.00	100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	132,221.79	132,221.79	100.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	56.00	56.00	0.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	0.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,160,091.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,160,091.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,660,091.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,908,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,752,091.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,160,091.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,160,091.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хангай сумын Засаг дарга нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй.

Тус сум нь тайлант онд “Төрийн байгууллага болон төрийн албан хаагчдыг манлайлах ур чадвартай, иргэдэд шуурхай үйлчилдэг, цомхон, чадварлаг төрийн алба бүрдүүлж хөгжлийн үзүүлэлтээрээ аймгийн зүүн бүсийн сумдын төв болох” гэсэн зорилт тавин ажиллажээ. Гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 91.17 хувиар үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хангай сумын Засаг дарга нь аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөв захирагч бөгөөд үйл ажиллагааг Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 2023. 01. 06-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон
- Төсвийн тухай хууль 2023.07.07-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон
- Хөдөлмөрийн тухай хууль 2023.07.07-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон
- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2023.06.16-ны өдөр нэмэлт, 2023.07.07-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 2023.07.07-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль 2023.06.16-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон
- Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай ЗГ-ын 2023.06.21-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор шинэчлэгдсэн
- "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-д ХХААХҮС-ын 2023.10.4-ны өдрийн А/521 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авахаар стандартад заасан байдаг.

Тайлант онд сумын Засаг даргын баталсан “Төрийн байгууллагуудад хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөө”-ний дагуу төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, журам, стандартыг баримтлан ажиллаж буй эсэхэд хяналт тавин ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хангай сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг аккрузал сууриар, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын хүрээнд бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлд аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/841 дүгээр захирамжаар баталсан “Аймгийн ТЕЗ-ийн багцын харьяа төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдсөн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хангай сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Хангай сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах ерөнхий орлогын болон 2 тусгай сан, 2 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, сумын ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төвүүдийн орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

Тайлант онд нийт хөрөнгийн дүн өмнөх оноос **264,221.8** мянган төгрөгөөр буюу 8.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /Мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	хувь
Б	1	2	3=2-1	4=3/1*100
Мөнгөн хөрөнгө	197,877.0	301,025.4	103,148.4	52.1
Авлага	300,352.4	345,416.6	45,064.2	15.0
Бараа материал	44,192.4	47,430.6	3,238.2	7.3
Нөөцийн бараа	48,011.5	40,825.0	-7,186.5	-14.9
Үндсэн хөрөнгө	2,497,478.5	2,617,436.1	119,957.6	4.8
Нийт хөрөнгө	3,087,911.8	3,352,133.6	264,221.8	8.5
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,087,911.8	3,352,133.6	264,221.8	8.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,087,911.8	3,352,133.6	264,221.8	8.5

Хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- **Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 52.1 хувиар өссөн байна.**

Мөнгөн хөрөнгө 301,025.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд 29.6 хувь буюу 89,318.5 мянган төгрөгийг орон нутгийн хөгжийн сангийн, 14.2 хувь буюу 42,903.2 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 56.0 хувь буюу 168,803.5 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл эзэлж байна. Ерөнхий орлогын үлдэгдлийн 64,709.2 мянган төгрөг нь төсөвт байгууллагуудын орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн шилжүүлэг, 104,094.3 мянган төгрөг нь сумын төсвийн давсан орлого байна.

- **Авлагын үлдэгдэл өмнөх оноос 15.0 хувиар өссөн байна.**

Авлагын эхний үлдэгдэл 300,352.4 мянган төгрөг бөгөөд тайлант онд хоршоо хөгжүүлэх сангаас олгосон 90,000.0 мянган төгрөгийн зээл, тайлант оны хүүгийн авлага 1,436.6 мянган төгрөг, ЗДТГ-ын хувь хүмүүсээс авах 27,548.7 мянга, ХХС-ийн 5,895.7 мянга, нийт 124,881.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 79,816.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулан 345,416.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ 345,416.6 мянган төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан 23 иргэн, ААН-ийн 316,441.1 мянган төгрөг, орон нутгийн ерөнхий орлогын 1,426.8 мянган төгрөг, ЗДТГ-н өвс тэжээлийн авлага 27,548.7 мянган төгрөгийн авлагыг үлдэгдэлтэй холбоотой байна.

- **Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 7.3 хувиар өссөн байна.**

Бараа материалын эхний үлдэгдэл 44,192.4 мянган төгрөг нь ЗДТГ-ын 41,734.5 мянган төгрөг, ИТХ-ын 2,457.8 мянган төгрөгийн үлдэгдэл бөгөөд тайлант онд ЗДТГ-д 60,839.7 мянган төгрөгийн, ИТХ-ын 6,736.8 мянган төгрөгийн худалдан авсан бараа материал, нийт 67,598.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 64,360.3 мянган төгрөгөөр хасагдаж 47,430.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансанд бичиг хэрэг 3,487.0 мянга, аж ахуйн материал 27,625.5 мянга, тусгай зориулалттай бараа материал 6,380.8 мянган төгрөг, эм боох материал 267.0 мянган төгрөг, түлш, шатаж тослох материал 668.7, барилгын засвар 31.4 мянган төгрөг, мал амьтан дээр 8,970.0 мянган төгрөг нийт 47,430.6 мянган төгрөгийн төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд энэ нь ЗДТГ-ын 44,566.7 мянган төгрөг, ИТХ-ын 2,863.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэл байна.

- **Нөөцийн барааны үлдэгдэл өмнөх оноос 17.9 хувиар буурсан байна.**

Нөөцийн барааны эхний үлдэгдэл 48,011.5 мянган төгрөг төсвийн хөрөнгөөр худалдан авсан 19,730.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 19,993.0 мянган төгрөг нийт 39,723.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 46,909.5 мянган төгрөгийн нөөцийн барааг зарцуулж 40,825.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. ЗДТГ-т өвс тэжээлийн нөөц 39,723.0 мянга төгрөгийн нөөцийн бараа нэмэгдсэн нь өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой байна.

- **Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 4.8 хувиар өссөн байна.**

Үндсэн хөрөнгө нь ЗДТГ-ын 2,497,478.5 мянга, ИТХ-ын 179,830.8 мянга нийт 3,122,047.2 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй бөгөөд тайлант онд худалдан авсан 3,479.9 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 320,362.6 мянган төгрөг /орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр бэлтгэгдсэн Баян-Улаан багийн барилга 127,010.7 мянга, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийсэн ойн зурвас, ойжуулалт 19,879.6 мянга, Ар баясгалан багийн барилга 114,872.3 мянга, Гичгэнэ багт хогийн цэг 5,000.0 мянга, Мал нядалгааны цех 53,600.0 мянган төгрөг/ нийт 323,842.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал 203,884.7 мянган төгрөгөөр хасагдаж 2,617,436.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 94.9 хувь буюу 2,485,561.1 мянган төгрөг нь ЗДТГ, 5.1 хувь буюу 131,874.8 мянган төгрөг нь сумын ИТХ-д бүртгэлтэй байна.

- **Цэвэр хөрөнгө өмч нь өмнөх оноос 8.5 хувиар өссөн байна.**

Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант үеийн үр дүнг 264,221.8 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Орон нутгийн төсвийн орлого, зардлын төлөвлөлт

Сумын 2023 оны төсвийн орлогыг 249,775.5 мянган төгрөгөөр төсөвлөн төсвийн төслийг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлжээ.

Хангай сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Сумын 2023 оны төсөв батлах тухай” 8 дугаар тогтоолоор сумын нийт төсвийг **1,236,086.5** мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд үүнээс сумын төсвийн орлогыг 220,669.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны төсөвт 2 удаа тодотгол орж өөрчлөгдсөн байна. Анх баталсан төсөв сүүлийн тодотгол хийсэн төсвийг харьцуулбал:

Аймгийн ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Аймгийн 2023 оны төсвийг тодотгон батлах тухай” 17 дугаар тогтоолын дагуу сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 05 дугаар тогтоолоор анхны тодотголоос сумын төсвийн орлогыг 13,960 мянга, аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 118,998.1 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 66,762.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,474,502.7 мянган төгрөгөөр буюу нийт төсвийг 238,416.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн дахин тодотгон баталсан байна.

Хүснэгт 2. Сумын төсвийн төлөвлөгөө

/мянган төгрөгөөр/

№	Байгууллага, орлогын нэр төрөл	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
1	Сумын төсвийн орлого	220,669.5	234,629.5	13,960.0
2	ТЕЗ-ийн харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого	140,560.0	140,560.0	-
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	484,041.1	603,039.2	118,998.1
4	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	285,944.7	352,706.7	66,762.0
5	2022 оны ОН-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	34,500.0	80,496.7	45,996.7
6	2022 оны ОНХС-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	70,371.2	63,070.6	(7,300.6)
	Нийт дүн-Орлого	1,236,086.5	1,474,502.7	238,416.2
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	76,787.9	115,795.8	39,007.9
2	Засаг даргын тамгын газар	481,893.1	611,540.0	129,646.9
3	Орон нутгийн хөгжлийн сан	409,312.5	468,773.9	59,461.4
4	Хоршоо хөгжүүлэх сан	110,560.0	110,560.0	-
5	Сургуулийн өмнөх боловсрол	29,122.3	34,622.3	5,500.0
6	Ерөнхий боловсролын сургууль	53,591.7	58,391.7	4,800.0
7	Соёлын төв	32,585.9	32,585.9	-
8	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	42,233.1	42,233.1	-
	Нийт дүн-Зардал	1,236,086.5	1,474,502.7	238,416.2

3.5.2 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл

Тайлант онд 14 нэр төрлийн 264,629.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 355,380.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, нийт 34.3 хувиар буюу 90,750.8 давж биелсэн байна.

Хүснэгт 3. Сумын төсвийн орлого

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл тийн хувь
1.НИЙТ ОРЛОГО	264,629.50	355,380.30	90,750.80	134.29
2.УРСГАЛ ОРЛОГО	264,629.50	355,380.30	90,750.80	134.29
3.ТАТВАРЫН ОРЛОГО	233,129.50	324,952.70	91,823.20	139.39
4.Орлогын албан татвар	150,434.00	236,391.30	85,957.30	157.14
Хүн амын орлогын албан татвар	150,434.00	236,391.30	85,957.30	157.14
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар	118,560.00	194,885.40	76,325.40	164.38
Үйл ажиллагааны орлого	6,100.00	7,926.00	1,826.00	129.93
Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү/	25,000.00	32,316.20	7,316.20	129.26
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	500	1,050.00	550	210.00
Орлогыг нь тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ	84	44.3	-39.7	52.74
Шууд бус орлого	190	169.4	-20.6	89.16
Өмчийн татвар	57,814.60	60,772.90	2,958.30	105.12
Малын тоо толгойн албан татвар	52,996.60	55,562.50	2,565.90	104.84
Үл хөдлөх хөрөнгийн татвар	708	770.4	62.4	108.81
Бууны албан татвар	4,110.00	4,440.00	330	108.03
Бусад татвар	17,878.80	20,710.90	2,832.10	115.84
Улсын тэмдэгтийн хураамж	2,530.00	1,353.10	-1,176.90	53.48
Газрын төлбөр	691.6	230.3	-461.3	33.30
-----газрын төлбөр	191.6	230	38.4	120.04
-----Газрын дуудлага худалдааны орлого	500	0.3	-499.7	0.06

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,200.00	6,552.80	4,352.80	297.85
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	12,457.20	12,574.70	117.5	100.94
Байгалийн нөөц ашигласны төлбөр:	7,002.10	7,077.60	75.5	101.08
.....Байгалийн ургамал ашигласны төлбөр	135	209.6	74.6	155.26
----- ус рашааны нөөц ашигласны төлбөр	900	900	0	100.00
-----ойн нөөц ашигласны төлбөр	5,835.10	5,836.00	0.9	100.02
-----ан амьтаны нөөц ашигласны төлбөр	132	132	0	100.00
5.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,500.00	30,427.60	-1,072.40	96.60
Төсөвт газрын өөрийн орлого	30,000.00	22,037.80	-7,962.20	73.46
Хүү торгуулийн орлого	1,000.00	4,889.80	3,889.80	488.98
Нэр заагдаагүй бусад орлого	500	3,500.00	3,000.00	700.00

Тайлант жилд орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлсэн хэдий ч төсөвт байгууллагын өөрийн орлого 7,962.2 мянган төгрөгөөр тасарсан нь өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой өвс тэжээлийн авлага үүссэнтэй холбоотой байна.

3.5.3 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 8 хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,474,502.7 мянган төгрөг төлөвлөснөөс 898,058.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 468,773.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 107,670.7 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгохоор төлөвлөсөн байна.

Нийт зардлын 56.8 хувь буюу 837,668.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 23.9 хувь буюу 352,706.7 мянган төгрөгийг ОНХС-аас 9.5 хувь буюу 140,560.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 9.7 хувь буюу 143,567.3 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр хуваарилжээ.

Төсвийн зардал 1,287,794.8 мянган төгрөг буюу 87.3 хувийн гүйцэтгэлтэй нь урсгал зардлаас 74,337.3 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 94,699.8 мянган төгрөг, ХХС-аас **17,670.7** мянган төгрөг хэмнэгдэн зарцуулаагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд малчдад тусламж хүргүүлэх тээвэр шатахууны зардалд 1,500.0 мянган төгрөгийн хувь хүнээс олгосон хандив, аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 1,052.0 мянган төгрөг, ГБХЗГ-аас 900.0 мянган төгрөг, хүүхэд хамгаалах хамтарсан багийн үйл ажиллагааны дэмжлэгт Аймгийн ИТХ-аас 300.0 мянган төгрөг, Аймгийн ЗДТГ-аас цэргийн бүртгэлийн шатахууны зардалд 408.0 мянган төгрөг нийт 4,160.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Хангай сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Пүрэвцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар хэрэгжүүлсэн.

Хангай сумын засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 01/58 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 1,474,502.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 22,117.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 16,588.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь Төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Үүний дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно.

Төсвийн шууд захирагчид нь тайлант оны төсвөөс нийт 64,709.2 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна. **Үүнээс тогтмол зардал 64,709.2 мянган төгрөг төвлөрүүлсэн.**

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хангай сумын засаг дарга нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 145 мэдээллээс 142 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан нь цахим системийн шинэчлэлтэй холбоотой байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Төсвийн шууд захирагчийн аудитын дүнгийн талаар

Сумын Засаг даргын харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Сумын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгдсэн ЗДТГ-т бие даасан дүгнэлт гаргаж, ИТХ, тусгай сангуудыг түүвэрт хамруулан шалгалаа.

Хангай сумын Засаг даргын нэгдсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудад хүргүүлсэн санал дүгнэлтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4. Аудитад хамрагдсан төсөв захирагчдад өгсөн санал дүгнэлт

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан
ЗДТГ	1	1	1		1		1		
ИТХурал	1	1		1					
ОНХС	1	1		1					
ХХС	1	1		1					
ЕБС /тогтмол зардал/	1	1			1	1			
Хүүхдийн цэцэрлэг /тогтмол зардал/	1	1			1	1			
ЭМТөв /тогтмол зардал/	1	1			1		1		
Соёлын төв /тогтмол зардал/	1	1		1					
НИЙТ ДҮН	8	8	1	4	5	2	2		

Сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 19,491,1 мянган төгрөгийн 4 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлсэн.

Хүснэгт 5. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Залруулсан алдаа	Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн	Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт		
			Тогтоосон төлбөрийн акт	Өгсөн албан шаардлага	Өгсөн зөвлөмж

Архангай аймгийн Хангай сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ			1	7,200.0	-	-	1	7,200.0	-	-
ИТХ			2	1,995.8	-	-	2	1,995.8	-	-
Соёлын төв			1	10,295.3			1	10,295.3		
НИЙТ ДҮН			4	19,491.1	-	-	4	19,491.1	-	-

➤ **Засаг даргын тамгын газар:**

ЗДТГ-ын газрын даргын 12 сарын 21-ны өдрийн А/24 дугаар тушаалаар 24 албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт 7,200.0 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон зөрчил илэрсэн.

Дээрх залруулагдаагүй зөрчил нь Сангийн Сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын “Үндсэн цалин” (210101) “Цалингийн сүлжээ, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа үндсэн болон байнгын гэрээт ажилтны албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана. Ажилтны үндсэн ажлын зэрэгцээ мэргэжил албан тушаалын хавсран хослон гүйцэтгэсэн, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ээлжийн амралтын олговор, сул зогсолтын үеийн олговор, хүндэтгэн үзэх шалтгаанаар ажилдаа ирээгүй үеийн олгох жирэмсэн болон амаржсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр хугацаагаар алдсаны ажлын эхний 5 өдрийн тэтгэмж энд хамаарна.” гэсэн заалтуудтай нийцэхгүй Төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

➤ **Иргэдийн Төлөөлөгчдийн хурал**

Хангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын 2023 оны 12 сарын 22-ны А/17 дугаар тушаалаар албан хаагчдад 600,000 төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтийг цалингийн сангаас, Хангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 14 дүгээр тушаалаар сумын ИТХ-ын даргад улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал 1,395.8 мянган төгрөг олгосон зөрчлүүд илэрсэн.

Дээрх залруулагдаагүй зөрчлүүд нь Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтын “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2-д “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

➤ **Соёлын төв**

Түлш халаалтын зардлаас тайлант онд 895.3 мянган төгрөгийг цахилгааны төлбөрт зориулалт бус зарцуулсан,

Хангай сумын засаг даргын 2023 оны 12 сарын 21-ны өдрийн Б/24, Соёлын төвийн даргын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар албан хаагчдад 9,400,000 төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтийг цалингийн сангаас олгосон зөрчил илэрсэн.

Дээрх залруулагдаагүй зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,” Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах

зааврын 210302 /түлш халаалт/, 210104 /Урамшуулал/ зардлын ангиллын зарцуулалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

➤ **ОНХС-ын талаар**

Сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 03-ны 05 дугаар тогтоолоор ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс 3 төсөл арга хэмжээнд 70,371.2 мянга, тайлант оны санхүүжилтээс шинээр эхлэх 9 төсөл арга хэмжээнд 352,706.7 мянга, малын тоо толгойн албан татварын орлогоос 5 төсөл арга хэмжээнд 45,696.0 мянга нийт 17 төсөл арга хэмжээнд 468,773.9 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр бүрэн хэрэгжсэн 11 төсөл арга хэмжээнд 364,074.0 мянга, дутуу хэрэгжсэн 1 төсөл арга хэмжээнд 10,000.0 мянга нийт 12 төсөл арга хэмжээнд 374,074.0 мянган төгрөгийг зарцуулсан бол 5 арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

ОНХС-ийн талаар аймгийн Аудитын газраас нийцлийн аудит хийхээр төлөвлөсөн тул уг аудитаар ТАХ-ний хэрэгжилтийг авч үзэх болно.

➤ **ХХС-ийн талаар**

ХХС нь 54,309.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэлтэй бөгөөд тайлант онд 31 аж ахуй нэгж, иргэнээс нийт 79,817.0 мянган төгрөгийн эргэн төлөлтийг бүрдүүлж, 5 иргэнд 90,000.0 мянган төгрөгийн зээл олгож, үйл ажиллагааны зардалд 1,223.5 мянган төгрөг зарцуулж үлдэгдэл 42,903.2 мянган төгрөг байна.

Сангийн авлагын эхний үлдэгдэл 298,925.5 мянган төгрөг бөгөөд тайлант онд олгосон 90,000.0 мянган төгрөг, өмнө олгосон зээлийн хүүгийн авлага 7,332.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, үндсэн зээлийн төлөгдсөн 72,484.5 мянга, хүүгийн орлого 7,332.4 мянга, нийт 79,816.9 мянган төгрөгөөр хасагдаж жилийн эцэст 316,441.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь 2011 оноос хойш зээл олгосон 39 иргэн аж ахуйн нэгжтэй холбоотой байна.

Тайлант онд нийт 116,684.2 мянган төгрөгийн авлагыг төвлөрүүлэхээс 79,816.9 мянган төгрөг төвлөрүүлсэн, үүнээс 5 иргэн 655.2 мянган төгрөгийн зээлийн илүү төлөлттэй байна. Хугацаандаа төлөгдөөгүй 37,522.4 мянган төгрөгийн зээлээс 2024 оны 01 дүгээр сард 01-ний өдөр иргэний 1,000.0 мянган төгрөг төвлөрч, 14 иргэн аж ахуйн нэгжийн 11,261.7 мянган төгрөгийн зээлийг Архангай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд эвлэрлийн гэрээ байгуулах хүсэлт хүргүүлсэн байна. Үлдсэн 25,260.7 мянга төгрөгийн авлагаас өмнөх онуудад албан шаардлага хүргүүлсэн боловч өнөөг хүртэл барагдуулаагүй 2011-2019 онд олгосон 4 иргэний нийт 15,111.0 мянган төгрөгийн зээлийн мэдээллийг аймгийн Прокурорын газарт судалгаагаар хүргүүлж, 2020 оноос хойш олгосон хугацаандаа эргэн төлөөгүй 4 иргэний 10,149.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг сумын Засаг даргад хүргүүлээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаас сумын төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр 6 нэр төрлийн 21,592.7 мянган төгрөгийн орлого тасарсанд холбогдох арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласнаар тайлант онд 5 нэр төрлийн орлого 9,699.1 мянган төгрөгөөр тасарсан орлого төлөвлөгөө нийт дүнгээрээ бүрэн биелсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт, ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн тусгасан байдал, Хоршоо хөгжүүлэх сангийн чанаргүй

зээлийн буцаан төвлөрүүлэлт болон "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын хэрэгжилтийг авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй нийт **10,149.6** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчлийг арилгуулах 1 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Зөвлөмж

5.1.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх санд 4 зээлдэгчтэй холбоотой 10,592.7 мянган төгрөгийн 3-5-аас дээш жилийн насжилттай чанаргүй зээлийн үлдэгдлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т "Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ", 11 зүйлийн 11.3-т "Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн чанаргүй зээлийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах .

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 04 дугаарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/ Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хоршоо хөгжүүлэх сан чанаргүй зээлийн үлдэгдлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна	1	10,149.6	-	-	-	-	1	10,149.6	0	0	0	0
Нийт	1	10,149.6	-	-	-	-	1	10,149.6	0	0	0	0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.